

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН
БАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ГСА-2025/21-6-ШТА-НА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас: 70543156,
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179 Цахим
хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Анхтуяа, Утас: 70543179 Цахим
хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Говьсүмбэр аймаг

2025

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер
Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Анхтуяа

Ахлах аудитор

Б.Дарханбат

Аудитор

С.Батцэцэг

Аудитор
Г.Ариунцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543179 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:
Говьсүмбэр аймаг, Сүмбэр
сум, 3 дугаар баг, Нутгийн
удирдлагын ордон, 205 тоот

2025 оны 05 дугаар сар

АГУУЛГА 3

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, тус хуулийг хэрэгжүүлэхэд зарим, зүйл заалтыг өөрчлөх шаардлагатай байна. 7

A.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5, 7, 10, 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлж ажилласан байна. 7

A.2 Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 15 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллагаагүй ба хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 15.2.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх боломжгүй байна. 9

Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журам нь бусад хуулиудтай нийцэхгүй байна. 12

B.1. Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтууд шинээр нэмэгдэж батлагдаж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна. 12

B.2. Цахим дэлгүүрт байршиж буй бараа, үйлчилгээний нэр төрөл цөөн, чанар үзүүлэлт муу, үнэ ханш өндөр байгаагаас худалдан авалт хийх сонирхолгүй байна. 14

Орон нутагт Төрийн аудитын байгууллагаас өөр хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна. 16

B.1 Төрийн аудитын байгууллага хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлсэн байна. 16

B.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэнээр бодит хэмнэлт бий болгоогүй, үр ашигтай ажиллаагүй байна. 17

B.3 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, жил бүр зөрчил давтагдсаар байна. 21

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

Тайлангийн хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГС

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ҮАГ	Үндэсний аудитын газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 05 дугаар тогтоол, МҮЕА-ын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаалыг үндэслэн болгон нийцлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан ҮАГ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу
2. Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу
3. Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай уялдуулан, ТЕЗ, тэдгээрийн харьяа байгууллагууд, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбар байгууллагууд, ОНӨААТҮГ-уудын 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж, холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Нийцлийн болон Санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглав.

- Монгол Улсын 2022, 2023, 2024 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд
- Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Хүндрэл бэрхшээл:

**ҮНДСЭН
МЭДЭЭЛЭЛ**


- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Анхтуяа, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг, Г.Ариунцэцэг нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын нээлтийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 05 дугаар сарын 06-ны дотор боловсруулан, дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлээ.

“Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах” 2, “Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудит 1, нийт 3 аудитын хугацаа давхацсантай холбоотойгоор аудитыг багаар гүйцэтгэхэд хүн хүчний хувьд дутагдал үүссэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь 2022 онд 4 бүлэг, 22 зүйл заалттай батлагдаж, Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.



2022-2024 оны СТА-аар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 149.5 сая төгрөгийн 58 зөрчил илэрсэн ба 16.0 сая төгрөгийн 14 төлбөрийн акт, 100.6 сая төгрөгийн 22 албан шаардлага, 32.9 сая төгрөгийн 22 зөвлөмж өгсөн байна. Шийдвэрийн хэрэгжилт 100%-тай байна.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аудитаар илэрсэн зөрчил / салбараар /	7
Дүрслэл 2	2022-2024 оны СТА-аар илэрсэн зөрчлийн нэгтгэл	15
Дүрслэл 3	Аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл	16
Дүрслэл 4	Аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 онд үүссэн бодит хэмнэлт / эдийн засгийн ангилал /	17
Дүрслэл 5	Хүүхэд хамгааллын зардлын зарцуулалт	18
Дүрслэл 6	2022-2024 оны СТА-аар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн дүн	20

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Зөрчил илэрсэн байгууллага, зөрчлийн утга, хуулийн зүйл, заалт / Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйл /	7-8
Хүснэгт 2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 зүйлд өөрчлөлт оруулах санал	8-9
Хүснэгт 3	Зөрчил илэрсэн байгууллага, зөрчлийн утга, хуулийн зүйл, заалт / Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл /	9-10
Хүснэгт 4	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд өөрчлөлт оруулах санал	10
Хүснэгт 5	2023, 2024 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа	11
Хүснэгт 6	2023, 2024 онд хуулийн хугацаанд багтааж зохион байгуулаагүй худалдан авах ажиллагааны жагсаалт	11-12
Хүснэгт 7	2022-2024 оны СТА-аар илэрсэн зөрчлүүд / Зөрчлийн утгаар /	15-16
Хүснэгт 8	Боловсролын салбарын байгууллагуудын 2023, 2024 онд үүссэн хэмнэлтийн задаргаа	17
Хүснэгт 9	Батлагдсан орон тоо, гүйцэтгэл / хүний тоогоор /	18
Хүснэгт 10	Тогтмол зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл	19
Хүснэгт 11	Халаалтын зардлын төсвийн задаргаа	19

БҮЛЭГ А

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, тус хуулийг хэрэгжүүлэхэд зарим, зүйл заалтыг өөрчлөх шаардлагатай байна.


А.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5, 7, 10, 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зорилт нь төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд хуулийн 3 дугаар зүйлд заасан үйлчлэх хүрээнд ТЕЗ, түүний харьяа байгууллагуудаас гадна дараах байгууллагуудыг түүвэрлэн аудитад хамрууллаа. Үүнд:

1. Боловсролын салбарын нийт байгууллагуудын 50% буюу 6 /Сүмбэр сумын 2 дугаар сургууль, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг, Баянтал сумын 4 дүгээр сургууль, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг, Шивээговь сумын 3 дугаар сургууль, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг /
2. Соёл урлагийн салбарын нийт байгууллагуудын 33% буюу 2 / Боржигон чуулга, Музей /
3. Эрүүл мэндийн салбарын нийт байгууллагуудын 60% буюу 3 / Нэгдсэн эмнэлэг, Шивээговь сумын Эрүүл мэндийн төв, Баянтал сумын Эрүүл мэндийн төв /
4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 3 /“Ус-Ду” ОНӨААТҮГ, “Талын Илч” ОНӨААТҮГ, “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ /

Тус нийцлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 404.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 18.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 345.3 сая төгрөгийн 11 албан шаардлага, 40.2 сая төгрөгийн 7 зөвлөмж өгсөн байна.

Дүрслэл № 01 Аудитаар илэрсэн зөрчил / салбараар /



Нийт илэрсэн зөрчлөөс 63%-ийг ОНӨААН, 20%-ийг Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, 17%-ийг боловсролын салбарын зөрчил эзэлж байна. Соёл урлагийн салбарын байгууллагуудад зөрчил илрээгүй байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой нийт 280.0 сая төгрөгийн зөрчил илэрч, 1.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 246.2 сая төгрөгийн 4 албан шаардлага, 32.6 сая төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

Хүснэгт № 01 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлтэй холбоотой илэрсэн зөрчлийг дэлгэрэнгүй харуулбал:

Зөрчлийн утга	Зөрчсөн хуулийн зүйл, заалт	Зөрчил гаргасан байгууллага, мөнгөн дүн	сая төгрөгөөр
			Аудитын шийдвэр
Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 ¹ , 4.1.6 ² , 12 дугаар	Сүмбэр сумын 2 дугаар сургууль-2.6 сая, Ус-Ду ОНӨААТҮГ-1.2 сая	Төлбөрийн акт 1.2 сая,

¹ үр ашигтай байх

² сахилга баттай байх

ашиггүй хоолны зардалд зарцуулсан	зүйлийн 12.1.4 ³ , Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 ⁴		зөвлөмж 2.6 сая
Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, урсгал шинжтэй үр ашиггүй зардалд зарцуулсан	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 12 дугаар зүйлийн 12.1.4	Шивээговь сумын 3 дугаар сургууль-12.7 сая, Баянтал сумын 4 дүгээр сургууль-2.8 сая, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг-1.8 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг-12.6 сая	Зөвлөмж-29.8 сая
Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй, төсвийн хөрөнгөөр гадаад сургалтад хамрагдсан	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 4.2.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.6.1, 6.6.2	Ус-Ду ОНӨААТҮГ-13.2 сая	Албан шаардлага-13.2 сая
Ашиг сонирхлын зөрчил үүсэх хамаарал бүхий этгээдтэй худалдан авалт хийсэн	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.6, 12 дугаар зүйлийн 12.1.4, НАНБАСЗАСЗУСТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг-8.3 сая	Албан шаардлага-8.3 сая
Удирдлагын зардлыг нэмэгдүүлж байгууллагын хөрөнгөөр суудлын автомашин худалдан авсан	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2	Ус-Ду ОНӨААТҮГ-179.8 сая, Талын Илч ОНӨААТҮГ-44.9 сая	Албан шаардлага-224.7 сая

Хүснэгтээс харахад нийт зөрчлийн 80.3% нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁵, 6.2⁶, 15.0% нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4⁷, 4.7% нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3⁸, 4.1.6⁹, 4.2.1¹⁰ дэх заалтуудтай холбоотой зөрчлүүд байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5, 7, 10, 11 дүгээр зүйлтэй холбоотой зөрчил илрээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйл, заалтын хэрэгжилтийг бодит нөхцөл байдалтай харьцуулахад хуульд нийцүүлэн гаргах норм норматив, жишгийг батлаагүй, хуулийн зарим заалт тодорхойгүй, хоёрдмол утга агуулгатайгаас хуулийг харилцан адилгүй өөр өөрөөр хэрэглэж байна. Тухайлбал, тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалтад өөрчлөлт оруулах, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг хүчингүй болгох хэрэгцээ шаардлага харагдаж байна.

Хүснэгт №02 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах санал

№	ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ	БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ	САНАЛ
1	7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.	Энэ хууль хэрэгжихээс өмнө Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчийн өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг	Өөрчлөлт оруулах санал: Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга,

³ хуулиар зөвшөөрөөгүй бусад

⁴ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁵ Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно

⁶ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно

⁷ хуулиар зөвшөөрөөгүй бусад

⁸ үр ашигтай байх

⁹ сахилга баттай байх

¹⁰ зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах

		жишиг” баталсан ба хуульд нийцүүлэн шинэчилж батлаагүй байна. Иймээс хуулийн энэ заалт хэрэгжээгүй байна.	хэрэгслийн нийтлэг жишгийг шинэчилж батлах
2	9.2.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ.	Үндэсний агаарын тээвэр нь бусад агаарын тээвэртэй харьцуулахад үнэ өндөр, зах зээлд өрсөлдөх эрхийг хязгаарласан заалт болсон. Мөн төрийн хэмнэлтийн тухай хууль нь нэг талаас зардлыг хэмнэх утга агуулгатай байтал өндөр үнэтэй үйлчилгээг сонгох нөхцөл байдалтай байна. Дээд шатны байгууллагуудаас хямд үнийг баримтлан гадаадын агаарын тээвэрлэгчийг сонгон үйлчлүүлэх чиглэл ирүүлж байна.	Хасах санал: Бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байгаа тул энэ заалтыг хүчингүй болгуулах саналтай байна.
3	10.2.Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно.	Энэхүү заалт нь хэрэгжүүлэхэд тодорхойгүй, хуулийг өөр өөрөөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Жишээ нь : Орон нутагт аймгийн ИТХ-ын зөвлөл, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, байгууллагын ёс зүйн зөвлөл, дэд хороо, үнэлгээний хороо, хөрөнгө оруулалтын ажил хүлээн авах комисс гэх мэт ажилладаг бөгөөд эдгээр нь бусад хууль журмын хүрээнд урамшуулал авахаар зохицуулагдсан байдаг	Өөрчлөлт оруулах санал: Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүн гэдэг тодорхойлолтод ямар субъектээс баталсан хэн орох талаар тодорхой болгох, бусад хуулиудтай нийцүүлж уялдуулах

Хуулийн хэрэгжилттэй холбоотой дээрх саналыг Үндэсний аудитын газарт уламжлах саналаар оруулахаар шийдвэрлэв.

А.2 Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд 15 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллагаагүй ба хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 15.2.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх боломжгүй байна.

Тус аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилттэй холбоотой нийт 124.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 17.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 99.1 сая төгрөгийн 7 албан шаардлага, 7.6 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт № 03 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлтэй холбоотой илэрсэн зөрчлийг дэлгэрэнгүй харуулбал:

Зөрчлийн утга	Зөрчсөн хуулийн зүйл, заалт	Зөрчил гаргасан байгууллага, мөнгөн дүн	/сая төгрөгөөр/ Аудитын шийдвэр

Өмнөх онтой харьцуулахад цэвэр усны хэрэглээ өссөнөөс хэмнэлт үүсээгүй	ТХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 15 дугаар зүйлийн 15.2.1	Сүмбэр сумын 2 дугаар сургууль-4.9 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг-2.7 сая	Зөвлөмж-7.6 сая
Хуулиар тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн байгууллагын ажилчдад давуу эрх олгон хөнгөлөлт эдлүүлсэн, хууль журмаар дагалдах мөнгөн шагналыг тогтоогоогүй байхад төрийн одон медалиар шагнагдсан мөнгөн шагнал олгосон	ТХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.3	Илчлэг шивээ ОНӨААТҮГ-0.8 сая, Талын Илч ОНӨААТҮГ-0.6 сая, Ус-Ду ОНӨААТҮГ-12.5 сая	Төлбөрийн акт-13.9 сая
Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 2 албан хаагчийг чөлөөлөөгүй, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан, хууль тогтоомж хэтрүүлэн урамшуулал олгосон	ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.2.6	Аймгийн Нэгдсэн эмнэлэг-58.9 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг-1.0 сая	Албан шаардлага-60.0 сая
Цалингийн зардлаас хууль журамд заагаагүй, хуулиар тогтоосон хэм хэмжээг хэтрүүлэн, давхардуулан шагнал, урамшуулал олгосон, төсвийн хөрөнгөөр туршлага солилцох шалтгаанаар гадаадад аялуулсан	ТХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 15 дугаар зүйлийн 15.1.3, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Аймгийн Нэгдсэн эмнэлэг-2.7 сая, Шивээговь сумын Эрүүл мэндийн төв-17.7 сая, Талын Илч ОНӨААТҮГ-1.3 сая	Төлбөрийн акт-2.9 сая, албан шаардлага-18.8 сая
Орон тоогүй, жишиг нормативт байхгүй орон тоонд төсвийн жилийн дундуур ажилтан авч ажиллуулсан, хавсран ажилласны нэмэгдэл цалин хөлс олгосон	ТХТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 4.1.9, 15 дугаар зүйлийн 15.1.2	Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг-5.8 сая, Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг-14.5 сая	Албан шаардлага-20.3 сая
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан	ТХТХ -ийн 15 дугаар зүйлийн 15.1.5	Талын Илч ОНӨААТҮГ-0.8 сая	Төлбөрийн акт-0.8 сая

Хүснэгтээс харахад нийт зөрчлийн 65% нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2¹¹, 15.2.6¹², 28.6% нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3¹³, 6.4% нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5¹⁴, 15.2.1¹⁵ дэх заалтуудтай холбоотой зөрчил илэрсэн байна.

Тус хуулийн 5-12 дугаар зүйл, заалтыг бодит нөхцөл байдалтай харьцуулахад дараах байдлаар хуульд өөрчлөлт оруулах саналтай байна.

Хүснэгт №04 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд өөрчлөлт оруулах санал

№	ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ	БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ	САНАЛ
1	15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах	Халаалтын тоолуур тавиулахад өндөр үнэтэй, хөрөнгө шийдвэрлүүлэхэд хүндрэлтэй, хуучин	Хасах санал: Бодит нөхцөл байдалтай нийцэхгүй тул энэ заалтыг хасах саналтай байна.

¹¹ чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох
¹² байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох
¹³ хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох
¹⁴ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс худалдан авах
¹⁵ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх

		барилгад тоолуур тавиулах боломжгүй байна.
2	15.2.4.цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх	Бичиг хэргийн зардлын төсөв бага батлагдаж ирдэг, хүрэлцээгүй байдаг.Албан хэрэг хөглөлтийг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа хэдий ч Архивын хуулийн дагуу цаасан хэлбэрээр архивлах хэрэгцээ шаардлага байгаа. Хүрэлцээгүй, бага батлагдаж ирсэн зардлыг дахин багасгаж хэмнэх боломж байдаггүй. Хасах санал: Бодит нөхцөл байдалтай нийцэхгүй тул энэ заалтыг хасах саналтай байна.

Хуулийн хэрэгжилттэй холбоотой дээрх саналыг Үндэсний аудитын газарт уламжлах саналаар оруулахаар шийдвэрлэв.

БҮЛЭГ Б

Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журам нь бусад хуулиудтай нийцэхгүй байна.

Б.1. Төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтууд шинээр нэмэгдэж батлагдаж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд 2023 онд 8,351.7 сая төгрөгийн 31, 2024 онд 10,591.9 сая төгрөгийн 46 худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Хүснэгт №05 2023, 2024 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа /сая төгрөгөөр/

Тайлант он	Батлагдсан төсөл арга хэмжээ		Амжилттай зохион байгуулсан төсөл арга хэмжээ		Амжилтгүй зохион байгуулсан төсөл арга хэмжээ		Зөрүү / Хэмнэлт /
	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
2023	31	8,351.7	26	7,361.5	5	882.3	108.0
2024	46	10,591.9	37	9,814.2	9	421.7	356.0
Нийт	77	18,943.6	63	17,175.7	14	1,304.0	464.0

2023-2024 онд 18,943.6 сая төгрөгийн 77 худалдан авах ажиллагаа зарлагдсанаас 17,175.7 сая төгрөгийн 63 худалдан авах ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж, 464.0 сая төгрөгийн хэмнэлт үүсэж, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2023 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанаас 882.3 сая төгрөгийн 5, 2024 онд 421.7 сая төгрөгийн 9 худалдан авах ажиллагаа амжилтгүй зохион байгуулагдаж, орон нутгийн төсөвт 1,304.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Худалдан авах ажиллагааг 2-6 удаа зарласан боловч амжилтгүй болсон байна. /Хавсралт №17 дэлгэрэнгүй үзнэ үү /

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1¹⁶-д заасан хугацаанд тухайн жилийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусаагүй нийт 2,357.4 сая төгрөгийн 12 ажил байна. Үүнээс 2023 онд 1,235.5 сая төгрөгийн 7, 2024 онд 1,121.9 сая төгрөгийн 5 худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд зохион байгуулагдаагүй байна.

Хүснэгт №06 2023, 2024 онд хуулийн хугацаанд багтааж зохион байгуулаагүй худалдан авах ажиллагааны жагсаалт

/ сая төгрөгөөр /

Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаа		Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон төсөвт өртөг	Зөрүү Хэмнэлт	Тайлбар
		Эхлэх	Дуусах			
2023 он						
Баянтал, Шивээговь сумдад нөөц генератор худалдаж авах	52.0	08/18	09/13	51.5	0.5	
Орон нутгийн өмчит байгууллагуудын их засварын ажил	364.9	06/07	08/24	364.4	0.5	Төсвийн тодотгол

¹⁶ батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

Стандарт хэмжилзүйн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	50.0	08/24	10/27	49.8	0.2	
УС-ДУ ОНӨААТҮГ аваарын нөөц генератор худалдаж авах	50.0	08/17	08/29	47.1	2.9	Төсвийн тодотгол
Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил	89.1	06/05	06/13	87.0	2.1	
Аймгийн өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх	80.0	08/17	10/13	77.0	3.0	Төсвийн тодотгол
Сүмбэр сумын Наран гэр хорооллын цахилгаан хангамжийн барилга угсралтын ажил	549.5	09/25	10/26	535.2	14.3	Төсвийн тодотгол
Нийт дүн	1,235.5			1,212.0	23.5	
2024 он						
Сүмбэр сумын 1 болон 5 дугаар сургуулийн сурагчдын бие засах өрөөний засварын ажил	139.4	11/19	11/27	138.3	1.1	Төсвийн тодотгол
Баяр наадамд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	75.0	07/09	07/19	75.0	-	Төсвийн тодотгол
Сүмбэр сумын 1 дүгээр сургуулийн фасад засвар, спорт заалны дотор их засварын ажил	682.0	06/11	07/14	681.1	0.8	Төсвийн тодотгол
640 хүүхдийн сургуулийн барилгын их засварын ажлын зураг төсөв боловсруулах	90.0	10/23	11/06	81.0	9.0	Төсвийн тодотгол
Тагтын эгнээний 0.4 кВа-ийн кабел сольж, Гашууны эгнээд КПа барих ажил	135.5	08/01	09/25	135.2	0.3	
Нийт дүн	1,121.9			1,110.6	11.3	

Эх сурвалж: 2023, 2024 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны жагсаалт

Хүснэгтээс харахад 2023 онд 1,044.4 сая төгрөгийн 4, 2024 онд 986.4 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ төсвийн жилийн дундуур тодотголоор шинээр нэмэгдсэнээс шалтгаалан хуулийн хугацаанд багтааж худалдан авах ажиллагаа явагдаагүй байна.

Төсвийн тодотголоор шинээр төсөл, арга хэмжээ нэмэгдэж батлагдаж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх боломжгүй, хуульд нийцэхгүй байгааг харуулж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дээрх заалтуудыг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуультай нийцүүлж өөрчлөх шаардлагатай байна. Хуулийн зүйл заалтыг бусад хуулиудтай уялдуулан өөрчлөх саналыг Үндэсний аудитын газар уламжлахаар шийдвэрлэв.

2023, 2024 онд улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын жагсаалтад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3¹⁷, 13.4¹⁸ дахь заалтуудад тусгасан хориглосон төсөл, арга хэмжээнүүд батлагдаагүй байна.

¹⁷ Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно

¹⁸ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно

Б.2. Цахим дэлгүүрт байршиж буй бараа, үйлчилгээний нэр төрөл цөөн, чанар үзүүлэлт муу, үнэ ханш өндөр байгаагаас худалдан авалт хийх сонирхолгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд “Цахим худалдан авалт”-ын талаар тусгасан байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын хэмжээнд 2023, 2024 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1¹⁹-д зааснаар тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт өгөөгүй байна.

2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй ба 2024 онд аймгийн ЗДТГ 39.4 сая, ХААГ 6.1 сая, нийт 45.5 сая төгрөгийн 2 удаагийн худалдан авалт хийсэн байна. Аймгийн ХААГ-аас цахим дэлгүүрийн талаар тодруулахад цахим дэлгүүрийг манайх хариуцдаггүй, мэдээлэл байхгүй, төрийн худалдан авах ажиллагааны газар хариуцдаг гэсэн тайлбарыг өгсөн.

Аудитын явцад шалгагдагч байгууллагуудаас авсан цахим худалдан авалт, цахим дэлгүүр/-ийн талаар санал асуулгад нийт 31 байгууллагын албан хаагчид / удирдлага, санхүүгийн ажилтнууд/ хамрагдсан байна.

Санал асуулгын дүнг нэгтгэн харуулбал:

1. **Цахим дэлгүүрийн талаар та мэдэх үү?** асуултад 58.6% буюу 17 нь бага зэрэг мэднэ, 27.6% буюу 8 нь маш сайн мэднэ, 4 буюу 13.8% нь мэдэхгүй гэж хариулсан байна.
2. **Цахим дэлгүүрийн талаар мэдээ, мэдээллийг хаанаас авч байсан бэ?** асуултад 9 буюу 29% нь олон нийтийн цахим хуудас, 6 буюу 19.3% нь аймгийн ХААГ, 13 буюу 41.9% бусад, 1 буюу 3.2% нь телевиз, сонин, сэтгүүл, 2 буюу 6.6% нь мэдэхгүй гэж хариулсан байна.
3. **Танай байгууллага цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээнээс худалдан авалт хийж байсан уу?** асуултад 23 буюу 74.2% нь үгүй, 7 буюу 22.6% нь тийм 1-ээс дээш удаа, 1 буюу 3.2% нь тийм 1 удаа хийж байсан гэж хариулсан байна.
4. **Цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байсан бол цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээ худалдан авагчийн хэрэгцээ шаардлагад нийцдэг үү? цахим дэлгүүрийн бараа, үйлчилгээний үнэ зах зээлийн үнэ ханштай нийцдэг эсэх, цахим дэлгүүрийн нэр төрлийн талаар санал бодлоо хуваалцана уу.**

Нээлттэй асуултад нийт 21 хүн хариулт илгээсэн байна. Үүнд:

- Худалдан авалт хийж байгаагүй -7
 - Зах зээлийн үнэ ханштай харьцуулахад хэтэрхий өндөр үнэтэй, нэр төрөл цөөн, сонголт муу-12
 - Цаг хугацаа их зарцуулдаг, зээлээр худалдан авалт хийгддэггүй-1
 - Чанаргүй, хуурамч бараа ирдэг -1
5. **Цахим дэлгүүрийн үйл ажиллагааг сайжруулах талаар таны санал**

Нээлттэй асуултад нийт 22 хариулт ирүүлсэн байна. Үүнд:

- Цахим дэлгүүрт байршиж буй барааны нэр төрлийг нэмэх, сонголттой болгох-6
- Барааны үнийг зах зээлийн үнэ ханштай нийцүүлж, хямдруулах-6
- Орон нутагт хүргэлттэй болгох / хүргэлт үнэгүй /-3
- Цахим дэлгүүрийн талаар сургалт зохион байгуулах-2

¹⁹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

- Цахим залилан ихсэх тул хэрэггүй үйл ажиллагаа-1
- Байхгүй-6


Санал асуулгын дүнг нэгтгэж үзэхэд санал асуулгад оролцсон дийлэнх албан хаагчид цахим дэлгүүрийн талаар мэдээ, мэдээлэл дутмаг, цахим дэлгүүрээс худалдан авалт бараг хийдэггүй, хийхгүй байгаа шалтгаан нь нэр төрөл цөөн, сонголтгүй, чанар муу, зах зээлийн үнэ ханштай харьцуулахад үнэ харьцангуй өндөр байгаа гэж хариулсан байна.

БҮЛЭГ В

Орон нутагт Төрийн аудитын байгууллагаас өөр хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна.

Аймгийн хэмжээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1²⁰-д зааснаар төрийн аудитын байгууллага 2022-2024 оны СТА-аар горим, сорилыг төлөвлөж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд өөр байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна. Орон нутагт төрийн аудитын байгууллагаас өөр хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна.

Дүрслэл №02 2022-2024 оны СТА-аар илэрсэн зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр /



Дүрслэлээс харахад: 2022-2024 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 149.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Зөрчлийн дүн 2023 онд өмнөх онтой харьцуулахад өссөн бол 2024 онд зөрчлийн дүн өмнөх оноос буурсан байна.

Илэрсэн зөрчлүүдийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зүйл, заалт, зөрчлийн утгаар нь дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт №07 2022-2024 оны СТА-аар илэрсэн зөрчлүүд / Зөрчлийн утгаар /
/ сая төгрөгөөр /

Хуулийн зүйл, заалт	Зөрчлийн утга		
	2022	2023	2024
4 дүгээр зүйл	-	4.1.3, 4.1.6-Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардалд зарцуулсан /хоол, бэлэг г.м/-13.2 сая	4.1.3, 4.1.6- Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зардалд зарцуулсан /хоол/-3.4 сая
6 дугаар зүйл	-	6.4 Албан тушаалын болон албан хэрэгцээний автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй-12 байгууллага	-
8 дугаар зүйл	-	-	8.1 Төсвийн хөрөнгөөр гамшгаас хамгаалах бэлэн байдлын хувцас худалдан авсан-3.3 сая
9 дүгээр зүйл	-	9.2 Үндэсний агаарын тээврийн компаниар зорчоогүй-1.9 сая	9.2 Үндэсний агаарын тээврийн компаниар зорчоогүй-11.0 сая
11 дүгээр зүйл	11.1 Байгууллагын дотоод журам тус заалттай нийцээгүй	-	-
12 дугаар зүйл	-	-	12.1.1 Төсвийн хөрөнгөөр гар утасны төлбөр, нэгж худалдан авсан-0.7 сая
13 дугаар зүйл	-	-	13.1.2 Аймгийн ОНХС 4 ТАХ-ний 717.7 сая төгрөгийн санхүүжилтийг

²⁰ Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.

			хэмнэлтэд зарцуулсан	тооцоогүй,
15 дугаар зүйл	15.1.3, 15.1.4, 15.1.6, 15.1.7, 15.2.3, 15.2.4, 15.2.6-39.2 сая	15.1.3, 15.1.5, 15.2.1, 15.2.3, 15.2.4, 15.2.5, 15.2.6-70.0 сая	15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.2.6-31.3 сая	

Эх сурвалж: FAS санхүүгийн аудитын систем

Хүснэгтээс харахад 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4, 6, 8, 9, 12, 13 дугаар зүйлтэй холбоотой зөрчил илрээгүй, 15 дугаар зүйлтэй холбоотой 39.2 сая, 2023 онд 4, 6, 9, 15 дугаар зүйлтэй холбоотой 60.7 сая, 2024 онд 4, 8, 9, 12, 13, 15 дугаар зүйлтэй холбоотой 49.6 сая, нийт 149.5 сая төгрөгийн зөрчил 58 байгууллагад илэрсэн ба 16.0 сая төгрөгийн 14 төлбөрийн акт, 100.6 сая төгрөгийн 22 албан шаардлага, 32.9 сая төгрөгийн 22 зөвлөмж өгсөн байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилт 100%-тай байна.

Аймгийн хэмжээний байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Тэргүүн дэд, дэд, орлогч дарга ажиллуулсан эсэх”, 10 дугаар зүйл “Цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоосон эсэх”-тэй холбоотой зөрчил илрээгүй байна.

1. Аймгийн ТЕЗ:

2023, 2024 оны СТА-аар аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт давхардсан тоогоор 19 байгууллагад 48.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 10.9 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 30.7 сая төгрөгийн 8 албан шаардлага, 6.7 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн байна.


Нийт илэрсэн зөрчлүүдээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлтэй холбоотой 51.3%, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалттай холбоотой 26.5%, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалттай холбоотой 6.8%, 4 дүгээр зүйлтэй холбоотой 7%, бусад заалттай холбоотой зөрчил 8.4%-ийг тус тус эзэлж байна. Аудитын шийдвэрийн хэрэгжилт 100%-тай байна.

В.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэнээр бодит хэмнэлт бий болгоогүй, үр ашигтай ажиллаагүй байна.

1. Аймгийн ТЕЗ

Аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад 2023 онд 22,223.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 81.2%-тай, зардлын хэмнэлт 4,169.0 сая, 2024 онд 34,151.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 83.9%-тай, 5,481.9 сая төгрөгийн зардлын хэмнэлт тус тус үүссэн байна. /Хавсралт 15-аас дэлгэрэнгүйг үзнэ үү/


Дүрслэл №03 Аймгийн ТЕЗ-ийн 2023, 2024 оны батлагдсан төсөв, гүйцэтгэл /сая төгрөгөөр/




Эх сурвалж: 2023, 2024 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2023 онд үүссэн хэмнэлтээс 65.6% буюу 2,734.4 сая, 2024 онд үүссэн хэмнэлтээс 46.5% буюу 2,550.5 сая төгрөгийн хэмнэлт нь төлөвлөсөн үр дүнд хүрээгүйгээс үүссэн бодит бус хэмнэлт байна. Бодит бус хэмнэлтэд голлох нөлөө үзүүлж буй шалтгаан нь төрийн байгууллагуудад хүний нөөцийн дутагдлаас үүдэн орон тоо дутуу ажилласнаас цалин сан, НДШ зардал зарцуулагдаагүй үлдэх, төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ тайланд оны зорилтот түвшинд хүрэхгүй ондаа багтаж хийгдэхгүй байх, он дамжин хийгдэж байгаатай холбоотой байна.

Дүрслэл №04 ТЕЗ-ийн 2023, 2024 онд үүссэн бодит бус хэмнэлтийг эдийн засгийн ангиллаар нь харуулбал:



2023 онд үүссэн бодит бус хэмнэлтийн 46% нь урсгал шилжүүлэг /аймаг, сумдын ОНХС-ийн арга хэмжээний зардлын хэмнэлт 440.1 сая /, 17% нь бараа үйлчилгээний бусад зардал, 14% нь тогтмол зардал, 11% нь цалин хөлс, НДШ-ийн зардал /20 орон тоо дутуу ажилласан / 11% нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр /мэдээлэл технологийн үйлчилгээ 101.0 сая / 1% нь бусад зардлын хэмнэлт эзэлж байна.



2024 онд үүссэн бодит бус хэмнэлтийн 39% цалин хөлс, НДШ-ийн зардал /26 орон тоо дутуу ажилласан/, 22% нь урсгал шилжүүлэг / аймаг, сумдын ОНХС-ийн арга хэмжээний зардлын хэмнэлт 414.6 сая /22% нь бараа үйлчилгээний бусад зардал, 10% нь тогтмол зардал, 5% нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, 2% нь бусад зардлын хэмнэлт эзэлж байна.

2. Боловсролын салбарын байгууллагууд

Аймгийн Боловсролын салбарын байгууллагуудад 2023 онд 16,208.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 92.7%-тай, зардлын хэмнэлт 1,176.1 сая, 2024 онд 22,736.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 90.5%-тай, 2,157.6 сая төгрөгийн зардлын хэмнэлт тус тус үүсэж, үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Хүснэгт №08 Боловсролын салбарын байгууллагуудын 2023, 2024 онд үүссэн хэмнэлтийг харуулбал:

Зардлын ангилал	Хэмнэлтийн мөнгөн дүн / сая төгрөгөөр/	
	2023	2024
Цалин хөлс, НДШ	850.9	1,810.2
Тогтмол зардал	154.8	139.3
Нормативд зардал	70.5	77.4
Эд хогшил, урсгал засварын зардал	-	6.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	18.4	2.8
Бараа үйлчилгээний бусад зардал	6.3	59.3
Урсгал шилжүүлэг	75.2	62.3
Нийт дүн	1,176.1	2,157.6

Эх сурвалж: Боловсролын салбарын 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн судалгаа

Хүснэгтээс харахад нийт хэмнэлтийн 72.3-83.9%-ийг цалин, хөлс, НДШ-ийн зардал, 6.4-13.2%-ийг тогтмол зардал, 3.6-6.0%-ийг нормативд зардал /дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол/, 2.9-8.8%-ийг урсгал шилжүүлэг /үдийн цай / бусад зардал 2.1-2.9%-ийг тус тус эзэлж байна.

Аймгийн Боловсролын газраас хэмнэгдсэн зардлын талаар шалтгаан тайлбарыг тодруулахад дараах тайлбарыг ирүүлсэн байна. Үүнд:

1. Цалин хөлс, НДШ-ийн зардлын хэмнэлт нь жилийн эцэст БЕГ-аас хэмнэгдэж байгаа төсвөө бүх аймгийн сургууль цэцэрлэгүүд рүү санхүүгийн жил дуусах үед шилжүүлж, дараа ондоо багш нарын амралтын мөнгө олгох үед эхний үлдэгдлийн эрхийг нээж өгч зарцуулдагаас үүссэн
2. Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг ашиглалтад орохоор төлөвлөж тогтмол зардлыг нэмэгдүүлж баталсан боловч ашиглалтад орохгүйн улмаас хэмнэлт үүссэн
3. Сургуулийн дотуур байр, үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал нь хүүхдийн тоо, ирцээс шалтгаалан хэмнэлт үүссэн
4. 2024 онд багш хөгжлийн зардлыг зарцуулах журам эцэслэгдэн батлагдаж гараагүй тул зарцуулагдаагүй үлдсэнээс хэмнэлт үүссэн

Эндээс дүгнэхэд боловсролын салбарын байгууллагуудад үүссэн хэмнэлт нь бодит бус хэмнэлт байна. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй байгууллагууд зарцуулаагүй үлдсэн төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэхгүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарчим, үйлчлэлтэй нийцэхгүй байна.

Аудитын талбарт хамрагдсан 14 байгууллагаас тогтмол зардал, орон тоо, хүүхэд хамгааллын зардлыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Тухайлбал,

1. Орон тоо

Хүснэгт №09 Батлагдсан орон тоо, гүйцэтгэл / хүний тоогоор /


Батлагдсан орон тоо /2023 /			Батлагдсан орон тоо /2024 /			Тайлбар
Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	
621	547.5	73.5	628	561.5	66.5	

Аудитад хамрагдсан 14 байгууллагад 2023 онд 621 орон тоо батлагдсанаас гүйцэтгэл 88.2%, 2024 онд 628 орон тоо батлагдсанаас гүйцэтгэл 89.4%-тай байна. Орон нутагт ажиллах боловсон хүчин олдохгүй, орон тоо дутуу ажилладгаас шалтгаалан цалин, хөлсний зардалд хэмнэлт үүсэж байна.

2. Хүүхэд хамгааллын зардал

Дүрслэл №05 Хүүхэд хамгааллын зардлын зарцуулалт

- Итгэлтэй утас
- Хөрөнгийн зардал
- Шинжилгээний төлбөр
- Сургалтын зардал
- Шатахуун
- Уралдаан тэмцээн
- Сургалтын хэрэглэгдэхүүн
- Бусад



Боловсролын салбарын байгууллагуудад 2024 оноос эхлэн хүүхэд хамгааллын зардал батлагдаж эхэлсэн байна. Аудитын талбарт хамрагдсан 6 байгууллагуудад хүүхэд хамгааллын зардалд 16.7 сая төгрөг батлагдсан ба гүйцэтгэлээр 100% зарцуулсан байна. Нийт зардлын 26%-ийг уралдаан тэмцээний зардалд, 20%-ийг сургалтын хэрэглэгдэхүүнд, 13%-ийг сургалтын зардалд, 11%-ийг шинжилгээний төлбөрт, 9%-ийг бусад зардалд, 9%-ийг хөрөнгийн зардалд, 7%-ийг шатахууны зардалд, 5%-ийг итгэлтэй утасны төлбөрт тус тус зарцуулсан байна.

Хүүхэд хамгааллын зардлыг зарцуулах журам батлагдаагүйн улмаас байгууллагууд янз бүрийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

3. Тогтмол зардал

Хүснэгт №10 Тогтмол зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл / сая төгрөгөөр /

Зардлын нэр	Батлагдсан төсөв /2023 /			Батлагдсан төсөв /2024 /			Тайлбар
	Төл	Гүйц	Зөрүү	Төл	Гүйц	Зөрүү	
Гэрэл цахилгаан	266.2	227.3	38.9	238.3	213.7	24.6	
Цэвэр, бохир ус	191.3	210.7	(19.3)	316.0	262.3	53.7	
Түлш халаалт	1,685.8	1,599.6	86.2	2,316.2	2,148.3	168.0	
Нийт дүн	2,143.3	2,037.5	105.8	2,870.5	2,624.2	246.3	

Аудитад хамрагдсан 14 байгууллагын тогтмол зардалд 2023 онд 2,143.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэл 95%, 2024 онд 2,870.5 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэл 91.4%-тай байна.

Цэвэр, бохир усны зардлыг нийт ашигласан хэрэглээтэй тулгахад 2024 оны хэрэглээ өмнөх онтой харьцуулахад 1,629 тонноор нэмэгдсэн байна. Нэмэгдсэн шалтгааныг тодруулахад Сүмбэр сумын 2 дугаар сургууль, 5 дугаар цэцэрлэг цэвэр, бохир усны хэрэглээ хянаагүй, үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан, Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга төсвийн жилийн дундуур ашиглалтад орсноос шалтгаалсан байна.

Байгууллагуудад халаалтын зардлын төсвийг талбайн хэмжээ, халаах сарыг тооцолгүйгээр баталсан байна.

Хүснэгт № 11 Халаалтын зардлын төсвийн задаргаа /2023 он /

Байгууллагын нэр	Талбайн хэмжээ	Халаах сар	Үнэ тариф	Нийт халаалтын төлбөр	Батлагдсан төсөв	Зөрүү
Сүмбэр сумын 2 дугаар сургууль	17438.2	8	2100	293.0	292.7	0.3
Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг	7416	8	2310	137.0	150.0	(13.0)

Шивээговь сумын 3 дугаар сургууль	10080	8	2310	186.3	185.5	0.8
Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэг	1330	8	2310	24.6	29.6	(5.0)
Баянтал сумын 4 дүгээр сургууль	11832	8	2310	218.7	209.4	9.3
Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг	1898	8	2310	35.1	35.1	-
Нийт дүн				894.7	902.3	(7.6)

Хүснэгтээс харахад тогтмол зардлыг 3 байгууллагад 10.4 сая төгрөгөөр дутуу, 2 байгууллагад 18.0 сая төгрөгөөр илүү тооцоолж баталсан байна.

Иймд Боловсролын газар, Эрүүл мэндийн газрын төсөв хариуцсан мэргэжилтнүүд салбар байгууллагуудын батлагдсан төсөв, зарцуулалтад дүн шинжилгээ хийж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.


Аймгийн Эрүүл мэндийн газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас салбар байгууллагуудын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, батлагдсан төсөв, гүйцэтгэл, шалтгаан тайлбарыг нэгтгэж ирүүлээгүй байна.

В.3 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, жил бүр зөрчил давтагдсаар байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулах талаар заасан байна.

2022-2024 оны СТА-аар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитыг хослуулан гүйцэтгэсэн. Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна.

Дүрслэл №06 2022-2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр илэрсэн зөрчлийн дүн / сая төгрөгөөр /



Дүрслэлээс харахад 2022 онд 815.3 сая төгрөгийн 13 зөрчил илэрч байсан бол 2024 онд 2,165.6 сая төгрөгийн 29 зөрчил илэрсэн ба өмнөх онтой харьцуулахад 38.5%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, аудитын шийдвэрээр харуулбал:

2022	2023	2024
•815.3 сая төгрөгийн 12 албан шаардлага, 1 зөвлөмж	•3,458.0 сая төгрөгийн 23 албан шаардлага, 64.5 сая төгрөгийн 9 зөвлөмж	•1,624.0 сая төгрөгийн 11 албан шаардлага, 275.0 сая төгрөгийн 15 зөвлөмж, 266.5 сая төгрөгийн 2 хариуцлага тооцуулах албан шаардлага

СТА-аар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд жил бүр аудит хийж, албан шаардлага зөвлөмж хүргүүлж байгаа боловч жил бүр зөрчил давтагдсаар байна. Зөрчил давтагдаад байгаа шалтгаан нь удирдлага, санхүүгийн ажилтнууд тогтвор суурьшилгүй байнга солигддог, шилэн дансны тухай хуулийн талаар буруу ойлголттой, зөвхөн хяналтын байгууллагад зориулж мэдээлэл оруулах байдлаар ханддаг зэргээс шалтгаалж байна.

Төрийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгайлсан хуулийн хүрээнд хэрэгжүүлж байгаа атал Төрийн хэмнэлтийн тухай хуулиар давхардуулан хэрэгжүүлэхээр оруулсан тул тус хуулийн 20.5 дахь заалтыг хүчингүй болгох саналыг ҮАГ-т уламжлахаар шийдвэрлэв.

Аудитаар нийт 404.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 18.8 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 345.3 сая төгрөгийн 11 албан шаардлага, 40.2 сая төгрөгийн 3 зөвлөмжийг нийт 12 байгууллагад, аймгийн Засаг даргад 1, сумдын Санхүүгийн албаны дарга нарт 1, аймгийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газарт тус тус 1 зөвлөмж, Үндэсний аудитын газарт уламжлах 10 санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Бүлэг-1

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй, тус хуулийн зарим зүйл заалтыг бодит байдалтай нийцүүлж өөрчлөх шаардлагатай байна.

Бүлэг-2

- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журам нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуультай нийцэхгүй байна.
- Цахим дэлгүүрт байршиж буй бараа, үйлчилгээний нэр төрөл цөөн, чанар үзүүлэлт муу, үнэ ханш өндөр байгаагаас худалдан авалт хийх сонирхолгүй байна.

Бүлэг-3

- Орон нутагт Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд Төрийн аудитын байгууллагаас өөр хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр бодит хэмнэлт бий болгоогүй, үр ашигтай ажиллаагүй байна.
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй, жил бүр зөрчил давтагдсаар байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зүйл заалтуудыг бүрэн хэрэгжүүлэх талаар төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилт хангагдахгүй байгаа хуулийн зүйл, заалтуудад дүн шинжилгээ хийх, шалтгаан тайлбарыг тодруулах

Аймгийн Боловсролын газар, Эрүүл мэндийн газрын удирдлагуудад:

- Салбар байгууллагуудын хэмжээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийгдсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийж, аудитаас өгсөн шийдвэрүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах

Ерөнхий боловсролын сүргүүл, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт:

- Төсвийн хөрөнгийг хоолны зардалд зарцуулахгүй байх, арвиан хэмнэлттэй, үр ашигтай зардалд зарцуулж, хуулийн хэрэгжилтийг бүрэн хангах
- Байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр усны хэрэглээг тогтмол хянаж, хэмнэх
- Нөхөн хангалтын зардлыг журамд заасан зориулалтын дагуу арвиан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах

Сүмдын Санхүүгийн албаны дарга нарт:

- Төрийн сангийн үйл ажиллагааны журамд зааснаар харьяа байгууллагуудын дансны гүйлгээг хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн хийгдэж буй эсэхийг хянах, шаардлага хангаагүй тохиолдолд буцаах

УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар уламжлуулах саналтай байна. Үүнд:

№	ХУУЛИЙН ЗҮЙЛ, ЗААЛТ	БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ	САНАЛ
1	7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.	Энэ хууль хэрэгжихээс өмнө Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн албан хаагчийн өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг” баталсан ба хуульд нийцүүлэн шинэчилж батлаагүй байна. Иймээс хуулийн энэ заалт хэрэгжээгүй байна.	Өөрчлөлт оруулах санал: Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг шинэчилж батлах
2	9.2.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ.	Үндэсний агаарын тээвэр нь бусад агаарын тээвэртэй харьцуулахад үнэ өндөр, зах зээлд өрсөлдөх эрхийг хязгаарласан заалт болсон. Мөн төрийн хэмнэлтийн тухай хууль нь нэг талаас зардлыг хэмнэх утга агуулгатай байтал өндөр үнэтэй үйлчилгээг сонгох нөхцөл байдалтай байна. Дээд шатны байгууллагуудаас хямд үнийг баримтлан гадаадын агаарын тээвэрлэгчийг сонгон үйлчлүүлэх чиглэл ирүүлж байна.	Хасах санал: Бодит нөхцөл байдалтай нийцэхгүй байгаа тул энэ заалтыг хүчингүй болгуулах саналтай байна.
3	10.2.Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно.	Энэхүү заалт нь хэрэгжүүлэхэд тодорхойгүй, хуулийг өөр өөрөөр хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Жишээ нь : Орон нутагт аймгийн ИТХ-ын зөвлөл, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл, байгууллагын ёс зүйн зөвлөл, дэд хороо, үнэлгээний хороо, хөрөнгө оруулалтын ажил хүлээн авах комисс гэх мэт ажилладаг бөгөөд эдгээр нь бусад хууль журмын хүрээнд урамшуулал авахаар зохицуулагдсан байдаг	Өөрчлөлт оруулах санал: Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүн гэдэг тодорхойлолтод ямар субъектээс баталсан хэн орох талаар тодорхой болгох, бусад хуулиудтай нийцүүлж уялдуулах

4	13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах	Төсвийн тодотголоор шинээр төсөл, арга хэмжээ нэмэгдэж батлагдаж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх боломжгүй, хуульд нийцэхгүй байгааг харуулж байна.	Өөрчлөлт оруулах санал: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дээрх заалтуудыг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуультай нийцүүлж өөрчлөх шаардлагатай байна.
5	13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох		
6	13.1.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх		
7	15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах	Халаалтын тоолуур тавиулахад өндөр үнэтэй, төсөв хөрөнгө шийдвэрлүүлэхэд хүндрэлтэй, хуучин барилгад тоолуур тавиулах боломжгүй байна.	Хасах санал: Бодит нөхцөл байдалтай нийцэхгүй тул энэ заалтыг хасах саналтай байна.
8	15.2.4.цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх	Бичиг хэргийн зардлын төсөв бага батлагдаж ирдэг, хүрэлцээгүй байдаг.Албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа хэдий ч Архивын хуулийн дагуу цаасан хэлбэрээр архивлах хэрэгцээ шаардлага байгаа. Хүрэлцээгүй, бага батлагдаж ирсэн зардлыг дахин багасгаж хэмнэх боломж байдаггүй.	Хасах санал: Бодит нөхцөл байдалтай нийцэхгүй тул энэ заалтыг хасах саналтай байна.
9	20.5.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна	Төрийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тусгайлсан хуулийн хүрээнд хэрэгжүүлж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар давхардуулан хэрэгжүүлэхээр оруулсан байна.	Хасах санал: Давхардуулан хэрэгжүүлэхээр оруулсан тул энэ заалтыг хасах саналтай байна.

10. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилттэй байгууллагууд тухайн төсвийн жилд зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэхгүй байгаа асуудлыг /Боловсрол, Эрүүл мэнд, Соёл урлагийн салбар/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарчим, үйлчлэлтэй нийцүүлж, өөрчлөлт оруулах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/Факс: (976) 7054 3005,
И-мэйл: zdtg.gsa@gmail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn

2025.05.09 № А/487

танай 2025.05.09 -ны № 174 -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр
дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Уг тайлангийн төсөлд санал өгөх зүйлгүй байна.



Т.БАТ-ЭРДЭНЭ

Ахлах аудитор
В.Анхтүвшин
Саналыг дугаар
тайлангаар дагалд
гач мурулах
2025.05.09

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлд саналгүй гэж ирүүлсэн байна.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/14

Чойр

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад зөвлөсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Б.Анхтуяа)-д үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг)-т даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

422501025

